

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2014 ОНЫ 10 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ

Нэг.Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны талаар:

Тайлант сард аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийн ээлжит IX хуралдаан хуралдаж 6 асуудал хэлэлцэн 4 тогтоол баталлаа. Үүнд:

- Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2010-2014 оны төлөвлөгөөний биелэлт, 2015-2018 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийг хэлэлцэн баталлаа.
- Аймгийн хэмжээнд уул уурхайн талаар баримтлах бодлогыг шинэчлэн, байгаль орчин, эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийн тэнцлийг хангасан ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэхэд чиглэсэн бодлогын баримт бичгийг баталлаа.
- Аймгийн 2014 оны төсөвт тодотгол хийж төсвийн орлогыг 68541213.5 мянган төгрөг болгон тодотголоо.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, Шүүхийн шинжилгээний алба, Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газруудад ажиллаж үйл ажиллагаатай нь танилцах ажлыг зохион байгууллаа.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан, сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс “Архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх амьдрах ухааны ур чадварыг эзэмшүүлэх нь” сэдэвт сургалтыг Алтанбулаг, Хүдэр, Ерөө, Жавхлант зэрэг сумдад зохион байгуулж 800 гаруй багш, сурагчдыг хамрууллаа.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан, сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ээлжит хуралдаанаар Сэлэнгэ аймагт 2014 оны эхний 9-р сард үйлдэгдсэн гэмт хэрэг зөрчлийн шалтгаан, нөхцөл цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцээд аймгийн хууль сахиулах байгууллагуудын нэгдсэн зөвлөгөөнийг зохион байгуулахаар шийдвэрлэлээ.

2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:

Аймгийн Засаг даргын Тамгын газар, Сайхан сумын Засаг даргын Тамгын газар хамтран “Нутгийн захиргааны анхан шатны батлан хамгаалах бодлого үйл ажиллагааг хэрэгжүүлэх, сурталчлах нь” сэдэвт багийн засаг дарга нар болон нийгмийн ажилтнуудын дунд бүсчилсэн сургалтыг зохион байгууллаа.

Аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газраас жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч, өрхийн үйлдвэрлэгчдээ дэмжиж Орхон аймгийн Засаг даргын Тамгын газартай хамтран “Сэлэнгэд үйлдвэрлэв” үзэсгэлэн худалдааг Эрдэнэт хотод зохион байгууллаа. Үзэсгэлэн худалдаанд Шаамар, Сант, Баруунбүрэн, Баянгол сумдын жижиг дунд болон өрхийн үйлдвэрлэл эрхлэгч нар оролцлоо. Тус үзэсгэлэн худалдаанд иргэд 20 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнээр оролцож нийт 20.0 сая төгрөгийн борлуулалтыг хийлээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Том төрөөс Ухаалаг төр лүү” санаачилга, Үндэсний аюулгүй байдлын зөвлөмж, Төрийн албаны зөвлөлийн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймаг, сумдын хэмжээнд ухаалаг засаглал, иргэн төвтэй төрийн үйлчилгээний зарчмыг хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар харилцан мэдээлэл солилцох, туршлага судлах зорилгоор сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарын “Ухаалаг төрийн бодлого Сэлэнгэ аймагт” сэдэвт зөвлөлдөх уулзалтыг 2014 оны 10 дугаар сарын 29-ний өдөр зохион байгууллаа. Зөвлөлдөх уулзалтаар сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарын “Том төрөөс Ухаалаг төр лүү” бодлогыг сум орон нутагтаа хэрхэн хэрэгжүүлж буй болон Засгийн газрын 2014 оны “Төсвийн хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай”

147 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх мэдээллийг сонсож, тулгамдаж буй асуудлын талаар хэлэлцлээ.

Аймгийн төв Сүхбаатар суманд 2014 оны 10 дугаар сарын 20-ны өдөр “Нээлттэй хаалганы өдөр” арга хэмжээг “Ээлтэй үйлчилгээ-иргэн танд” уриан дор зохион байгууллаа. Энэ өдөр аймгийн Засаг дарга Сүхбаатар сумын иргэдтэй уулзах хуваарийг батлан 10:00-19:00 цагийн хооронд баг бүр дээр уулзалт зохион байгууллаа. Уулзалтаар 130 гаруй иргэдийн санал хүсэлтийг сонсож, төр засаг, аймаг орон нутгаас зохион байгуулж буй ажил арга хэмжээний талаар мэдээлэл хийн, иргэдээс гаргасан санал, хүсэлт, өргөдөл гомдлыг шийдвэрлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж байна. Тус арга хэмжээг угтан аймгийн Засаг даргын Тамгын газраас Сүхбаатар сумын нийт 150 иргэнээс аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар, хэлтэс албад, Сүхбаатар сумын Засан даргын Тамгын газрын төрийн албан хаагчдын үйл ажиллагааны талаар сануулга авч нэгтэн дүнг, аймгийн Засаг дарга иргэдтэй хийсэн уулзалтын үеэр танилцууллаа. Энэхүү “Ээлтэй үйлчилгээ-иргэн танд” арга хэмжээгээр 33 байгууллагын 100 гаруй төрийн албан хаагч давхардсан тоогоор нийт 3234 иргэнд үйлчилсэн.

Аймгийн Засаг даргын 2014 оны А/135 тоот захирамжийн хэрэгжилтийг хангаж 2014 оны 2-р ээлжийн цэрэг татлагыг Мандал, Сайхан, Сүхбаатар сумдад бүсчлэн зохион байгуулж, цэрэг татлагад хамрагдвал зохих нийт цэргийн насны залуучуудын 65.5 хувь нь үзлэгт хамрагдлаа. 2014 оны 2-р ээлжийн цэрэг татлагаар Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний жанжин штабаас ирүүлсэн хяналтын тоог 100 хувь биелүүлж ажиллалаа.

Тайлант сард аймгийн Засаг даргын Тамгын газрын 70361111 утсанд нийт 15 иргэн санал, хүсэлт гаргаснаас 9 асуудлыг шийдвэрлэж, 6 асуудал шийдвэрлэх шатандаа явж байна. Иргэдээс гаргасан санал хүсэлт нь төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааны талаар 4, байгаль орчны талаар 2, Сүхбаатар сумын дулаан хангамжийн талаар 4, нийтийн тээврийн үйлчилгээний талаар 1, төсөв санхүүгийн талаар 1, хот байгуулалтын талаар 3 байлаа.

3.ТҮЦ машины мэдээлэл:

2014 оны 09 сарын 20-оос 10 сарын 20-ны өдрүүдэд ТҮЦ машинаар үл хөдлөх хөрөнгийн лавлагаа 4, төрсний бүртгэлийн лавлагаа 7, цахим үнэмлэхний лавлагаа 185, цахим үнэмлэх захиалах 17, оршин суугаа хаягийн тодорхойлолт 103, гэрлэлтийн бүртгэлийн лавлагаа 16, хуулийн этгээдийн бүртгэлийн лавлагаа 4 нийт 336 иргэн үйлчлүүлсэн байна.

Бусад ажлын талаар:

1.Онцгой байдлын газар:

Улсын Онцгой комиссын 2014 оны 241 дүгээр тогтоолын дагуу 2014-2015 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах хүрээнд аймаг, сумдад орон нутгийн өвс тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэх тоо, хэмжээ, үнэ, хадгалах нөхцлийн судалгааг Улсын онцгой комисст хүргүүллээ.

“Газрын тосны бүтээгдэхүүний агуулах, шатахуун түгээх станц, шингэрүүлсэн хийн түлшний станц”-уудад Гамшгаас хамгаалах болон Галын аюулгүй байдлын тухай хууль, дүрэм норм стандартын хэрэгжилтийг шалгах төлөвлөгөөт шалгалт, “Авто зогсоол, авто засварын газрууд, авто үйлчилгээний байгууллагуудад гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын тухай хууль, дүрэм, норм, стандартын хэрэгжилтийг шалгах” төлөвлөгөөт шалгалт, Онцгой комиссын даргын баталсан “Намар” нэгдсэн арга хэмжээний удирдамжуудын хүрээнд 89 объект, аж ахуйн нэгж, байгууллагуудад гамшгаас урьдчилан сэргийлэх, хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, 456 зөрчил илрүүлж, зөрчлийг арилгуулахаар гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 71, мэдэгдэл 15, дүгнэлт 8 хууль тогтоомж, дүрэм,

журам зөрчсөн, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн шаардлагыг хэрэгжүүлээгүй 3 аж ахуйн нэгж, байгууллагыг 650.0 мянган төгрөгөөр 2 албан тушаалтныг 100.0 мянган төгрөгөөр торгож, захиргааны арга хэмжээ ногдууллаа.

“Газрын тосны бүтээгдэхүүний агуулах, шатахуун түгээх станц, шингэрүүлсэн хийн түлшний станц”-уудад Гамшгаас хамгаалах болон Галын аюулгүй байдлын тухай хууль, дүрэм норм стандартын хэрэгжилтийн шалгалтын хүрээнд, Сүхбаатар, Алтанбулаг, Баянгол, Мандал, Зүүнбүрэн, Сант, Хушаат, Орхон, зэрэг сумдад үйл ажиллагаа явуулж буй Дархан “НХС-ын шатахуун түгээх станцууд”, “Магнай трейд”, “Шунхлай петролеум”, “Тэс петролеум”, “Жаст ойл”, ХХК-иудын нийт 38 шатахуун түгээх станцуудад хяналт шалгалт хийхэд 327 зөрчлийг илрүүлж, үзлэг шалгалтын явцад 6 зөрчлийг барагдуулж, бусад зөрчлийг арилгуулахаар Улсын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 36, мэдэгдэл 2-ийг өглөө.

2014 оны 10 дугаар сард 5 удаагийн объектын гал түймэр гарснаас 3 гал түймэр дээр Аврах, гал унтраах анги ажиллаж, иргэд 2 гал түймрийг унтраасан.

Гал түймрийн шалтгаан нөхцлийг судалж үзвэл цахилгааны ашиглалт, угсралтын буруугаас 3, ил задгай гал асааснаас 2 удаа тохиолдсон байна.

2.Стандартчилал хэмжил зүйн хэлтэс:

Аймгийн Стандартчилал хэмжил зүйн хэлтсээс “Дэлхийн Стандартын өдөр”, “Үндэсний Чанарын 7 хоногийг тохиолдуулан, “Стандарт ижил тэгш өрсөлдөх боломжийг бий болгоно” сэдэвт сарын аян зараллаа.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Стандартчилал хэмжил зүйн хэлтсээс хамтран “Алтан тариа” ХХК, “Тариалан эрхлэлтийг дэмжих сан”-ийн Сэлэнгэ дэх салбарт “Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай “ хуулийн хэрэгжилтэнд хяналт, шалгалт хийлээ.

Сүхбаатар суманд үйл ажиллагаа явуулж буй Шатахуун түгээх станцын эрхлэгч, түгээгч нарт шинэчлэн гаргасан “Шатахуун түгээх станц, Техникийн ерөнхий шаардлага” MNS4633:2013 стандарт, Шатахуун түгээгүүр шалгах арга хэрэгсэл MNS 3015:2014 стандартын талаар мэдээлэл, стандартаар хангалаа

Худалдаа, үйлчилгээний газрын мөрдвөл зохих стандартын 84.0-өөс дээш хувийг хангасан үйлчилгээний газарт тохирлын гэрчилгээг шинээр олгох буюу хугацааг сунгах асуудлыг шийдвэрлэхээр Сүхбаатар, Мандал, Алтанбулаг сумын баталгаажуулалтын орон тооны бус салбар зөвлөлийн хурлыг хуралдуулж, тохирлын гэрчилгээг 2 үйлчилгээний газарт шинээр олгохоор, 7 худалдаа, нийтийн хоолны газруудад 1-2 жилээр сунгах шийдвэр гаргаж, тохирлын гэрчилгээг олголоо.

Сүхбаатар, Шаамар сумын 6 аж ахуйн нэгж иргэний 4 нэрийн 10 бүтээгдэхүүн, Дархан-Уул аймгийн “Сувд” нарийн боовны цехийн үйлдвэрлэсэн 1 нэрийн 2 бүтээгдэхүүнийг тус тус сайн дурын баталгаажуулалтанд хамруулж, итгэмжлэгдсэн лабораторийн сорилт, шинжилгээний дүнг үндэслэн шинжээчийн дүгнэлт гаргаж ажиллалаа.

“Редхилл Монголия” ХХК-ийн ОХУ-д экспортлож буй 730.75 тн чулуун нүүрсний 3 удаагийн тээвэрлэлтэнд тохирлын баталгаа гаргаж, гэрчилгээ олголоо.

Мандал, Сүхбаатар сумын айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагын төлбөрийн тооцоонд ашиглагдаж байгаа 1 фазын 953 ширхэг цахилгааны тоолуурыг ээлжит баталгаажуулалтанд хамрууллаа.

3.Мэргэжлийн хяналтын газар:

2014 онд Мэргэжлийн хяналтын газрын 63 улсын байцаагч аймгийн хэмжээнд төрийн хяналт шалгалт, зөвлөн туслах ажлыг хийж гүйцэтгэж байна. Тайлант хугацаанд 304 хуулийн этгээд, 524 иргэнийг хяналт шалгалтанд хамруулан, салбарын 24, байгууллагын 264 сургалт зохион байгуулж, 238 тандалт

судалгаа, 288 хяналт шинжилгээ, 145 урьдчилан сэргийлэх хяналтыг хэрэгжүүлж ажиллалаа.

Энэ хугацаанд улсын байцаагчдаас 273 удаагийн мэдэгдэх хуудас, 301 хяналт шалгалтын хуудас, 285 хяналт шалгалтын тэмдэглэл, 198 албан шаардлага, 98 акт, 249 дүгнэлт гаргаад байна.

Хяналт шалгалтаар 1368 зөрчил илрүүлж, 1123 зөрчлийг бүрэн арилгуулж, 445725.2 мянган төгрөгийн нөхөн төлбөр тогтоосноос 78669.6 мянган төгрөгийг төлүүлж, 82883.6 мянган төгрөгийн торгууль ногдуулж бүрэн барагдуулаад байна. Ногдуулсан, тогтоосон шийтгэвэрийг төлөхөөс зайлсхийсэн иргэд аж ахуйн нэгж байгууллагыг шүүхийн шийдвэр гүйцэтгүүлэх журмаар гаргуулан ажиллаж байна.

Сүхбаатар сумын “Тогоон чулуу” ХХК-ийн зорчигч тээвэрлэлтийн үйл ажиллагаа, Алтанбулаг сумын Ерөнхий боловсролын сургуульд хяналт шалгалт, зөвлөн туслах үйлчилгээ тус тус үзүүлж, шалгалтаар илэрсэн зөрчилд холбогдуулан 300.0 мянган төгрөгийн шийтгэврийн арга хэмжээ авлаа.

Өрхийн болон сумын эрүүл мэндийн төв, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын 85 эмч, удирдах албан тушаалтан нарыг оролцуулсан “Эрүүл мэндийн байгууллагуудын эмнэлгийн тусламж үйлчилгээг сайжруулахад дотоодын хяналтыг төлөвшүүлэх нь” сэдэвт салбарын сургалтыг зохион байгуулж, Сүхбаатар суманд үйл ажиллагаа явуулдаг хувийн хэвшлийн “Энэрэлт үйлс”, “Анар”, “Нямзул” эмнэлгүүдэд зөвлөн туслах үйлчилгээ үзүүллээ.

Сүхбаатар, Жавхлант, Хүдэр, Ерөө, Алтанбулаг сумын ерөнхий боловсролын 10 сургуульд “Үдийн цай” хөтөлбөрийн хэрэгжилт, орчны эрүүл ахуйн байдалд хяналт шалгалт хийж, хоол хүнсний 14 дээжийг лабораторийн шинжилгээнд хамруулж, эрүүл ахуй халдвар хамгааллын бэлэн байдлыг дүгнэж, зөвлөмж өгч ажиллалаа.

Хоёр.Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:

1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:

09-р сарын 30-ний байдлаар

/мянган төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1	Орон нутгийн төсвийн нийт орлого	1165480.7	11091466.5	95.5
	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	9498435.1	9129117.4	96.1
2	Орон нутгийн төсвийн нийт зарлага	56583919.20	47595726.80	84.1
	Үүнээс: Аймгийн төсвийн зарлагын дүн	16263387.9	12498119.0	76.8
	- Аймгийн ОНХСангийн зарцуулалт	4013570.70	2184048.30	54.4
3	Улсын төсвөөс олгосон ОНХСангийн орлогын шилжүүлэг	10411737.60	5298006.00	50.9
4	Улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг	3103465.10	3103481.60	100.0
5	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	5063915.80	5063915.80	100.0
7	Засаг даргын нөөц	456840.00	378552.70	82.9

2014 оны төсвийн гүйцэтгэлийн 9 сарын мэдээгээр орон нутгийн төсвийн орлого 95.5 хувь, улсаас авах санхүүгийн дэмжлэг 100.0 хувь, орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг 50.9 хувь, салбарын байгууллагуудын тусгай зориулалтын шилжүүлэг 100.0 хувь тус тус биелэгдсэн байна. Төсвийн зарлагын гүйцэтгэл 84.1 хувийн биелэлттэй байна. Аймгаас олгох сумдын санхүүгийн дэмжлэг 100 хувь, Засаг даргаас олгох нөөц хөрөнгийн гүйцэтгэл 82.9 хувийн

гүйцэтгэлтэй гарсан байна.

2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:

№	Барааны нэр, төрөл	Хэмжих нэгж	Үнэ, ханш /төгрөгөөр/	
			2013 оны 9-р сар	2014 оны 10-р сар
Нэг.Талх, гурил, будаа				
1	Гурил /1-гурил/	1 кг	1200	1200
2	Талх /орон нутгийн/ том, жижиг	ш	1000, 2200	1000, 2200
3	Нарийн боов	1 кг	1900-2500	1900-2500
4	Элсэн чихэр	1 кг	1800-2100	1800-2100
5	Цагаан будаа	1 кг	2200-2400	2200-2400
Хоёр.Мах, махан бүтээгдэхүүн				
6	Хонины мах	1 кг	7000	6500
7	Үхрийн мах	1 кг	8000	7500
8	Адууны мах	1 кг	6500	6000
9	Ямааны мах	1 кг	6000	5800
10	Дотор мах цувдай	1 кг	4000	4000
11	Хиам, чанасан	1 кг	9000	9000
12	Гахайн мах	1кг	6000	6000
Гурав.Сүүн бүтээгдэхүүн				
12	Сүү /задгай/	1л	800	800
13	Сүү /савласан/	1л	2500	2500
14	Тараг /задгай/	1л	900	1000
15	Хорхой ааруул	1 кг	8500	10000
16	Айраг	1л	-	-
17	Хуурай сүү /орос/	1 кг	4000	4000
18	Өндөг	ш	350	350
Дөрөв. Бүх төрлийн өөх тос				
19	Ургамлын тос	1 кг	2900-3300	2900-3300
20	Өөхөн тос	1 кг	1500	1500
21	Шар тос	1 кг	8000	8000
22	Масло /задгай/	1 кг	3200	3200
Тав.Хүнсний ногоо				
23	Төмс	1 кг	800	800
24	Лууван	1 кг	1000	1000
25	Манжин	1 кг	800	800
26	Байцаа	1 кг	800	800
27	Сонгино	1 кг	1000-1500	1000-1500
28	Өргөст хэмх	1 кг	-	-
29	Тарвас /Монгол/	1 кг	-	-
30	Өргөст хэмх /даршилсан/	ш	3500	3500
31	Алаг салат /даршилсан/	ш	1900-2500	1900-2500
Зургаа.Тээвэр шатахуун				
32	Бензин А-80	1 л	1590	1590
33	Бензин А-92	1 л	1700	1690
34	Дизель түлш	1 л	1830	1830

Гурав.Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

1. Архивын талаар:

Хууль зүйн яамны ажлын хэсэг Төрийн архивт Монгол Улсын Засгийн газрын 2006 оны 64 тоот тогтоолоор батлагдсан “Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа ажлын явц байдал, баримт бичгийн хадгалалт хамгаалттай танилцаж, тулгамдаж байгаа асуудлын талаар санал авлаа.

Архивын ерөнхий газарт 2015 онд зохион байгуулах мэргэжил олгох болон мэргэшүүлэх сургалтанд архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтнаа хамруулах талаар аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар хэлтэс албад болон сумын Засаг даргын Тамгын газруудаас санал авч, судалгаа гарган мэдээллийн бааз үүсгэлээ.

Төрийн архивын дэргэдэх Баримт бичиг нягтлан шалгах арга зүйн комиссын хурлаар 2014 онд иж бүрэн нягтлан шалгалтын ажилд хамрагдсан 11 хөмрөгийн шинэчлэгдсэн бүртгэл болон устгах бичгийн жагсаалт, “Сэлэнгэ энерго” ОНӨААТҮГ-ын байнга, түр, устгах бичгийн жагсаалт зэрэг нийт 12 асуудлыг хэлэлцүүлж баталлаа.

Төрийн архивын сан хөмрөгийг нөхөн бүрдүүлэх зорилгоор аймгийн Нийтийн номын сангийн 1990-2006 оны байнга хадгалагдах 65 хадгаламжийн нэгжийг бүртгэлийн дагуу цаасан болон цахим хэлбэрээр хүлээн авч шинээр хөмрөг үүсгэлээ.

Худалдаа бэлтгэлийн удирдах газрын хөмрөгийн 1959-1977 оны 78 хадгаламжийн нэгжид нягтлан шалгалтын ажлыг хийж, 51 хадгаламжийн нэгжид сэлбэн засалтын ажлыг хийж гүйцэтгэлээ.

Архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд Ерөө сангийн аж ахуйн 1971-1991 оны 29 хадгаламжийн нэгжийн 5654 хуудас баримтыг засварлаж ашиглалтын хувь үүсгэлээ.

Төрийн архивын “AMS” програмд Ерөө сангийн аж ахуйн хөмрөгийн 2 хадгаламжийн нэгжийн 379 хуудасны мэдээллийн агуулгыг уншиж 626 заалт, 1394 хүний нэр, 11 байгууллагын нэр, 22 газар зүйн нэрийг шивж орууллаа. Мөн Зүүнбүрэн сангийн аж ахуйн хөмрөгийн 4 хадгаламжийн нэгжийн 691 хуудсыг серверт задалж холболт хийлээ.

Ард иргэд, албан байгууллагын хүсэлтийн дагуу архивын хуулбар 122, цалингийн тодорхойлолт 1, магадлагаа 19, тодорхойлолт 16 гаргаж үйлчиллээ.

Дөрөв.Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:

1. Эрүүл мэнд, хүүхэд залуучуудын талаар:

Эрүүл мэндийн яам, аймгийн Засаг дарга болон, Айвико компанийн дэмжлэгтэйгээр 2014 оны 10-р сард аймгийн Нэгдсэн эмнэлэгт Гемодиализын тасгийг нээлээ.

Эрүүл мэндийн яам, аймгийн Эрүүл мэндийн газар хамтран 2014 оны 10 дугаар сарын 8-10-ны хооронд аймгийн Нэгдсэн эмнэлэг, Мандал сумын Нэгдсэн эмнэлэг, Сүхбаатар сумын өрхийн 3 эмнэлэг, Зүүнбүрэн сумын эрүүл мэндийн төвд эх хүүхдийн тусламж үйлчилгээний чанарт хяналт шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Аймгийн Засаг даргын 2014 оны А/135 тоот захирамжийн хэрэгжилтийг хангаж 2014 оны 2-р ээлжийн цэргийн жинхэнэ албаны татлагаар эрүүл мэндийн үзлэгт нийт 1182 цэргийн насны залуучууд хамрагдснаас 796 нь өвчлөлтэй гарлаа.

“Олон улсын охидын өдөр” тэмдэглэлт өдрийг тохиолдуулан “Хүүхэд бүр хүчирхийллээс ангид байх эрхтэй” уриан дор аймгийн охидын чуулганыг анх удаа Эрүүл мэндийн газар, Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтэс, Дэлхийн Зөн олон улсын байгууллагатай хамтран 2014 оны 10 сарын 11-ний өдөр зохион байгууллаа. Мөн ерөнхий боловсролын бүрэн дунд сургуулийн “Үе тэнгийн сургагч” 40

сурагчдад “Би ээж болно”, “Охид тэдний эрүүл мэндийг дэмжих нь”, “Хүүхэд бүхэн хүчирхийллээс ангид байх эрхтэй”, “Үе тэнгийн дарамт шахалт” зэрэг сэдвүүдээр сургалт зохион байгуулж, “Охидын шивнээ” ном өгч, оролцогчдоос сургалтын үнэлгээг хийлгэлээ.

Аймгийн Эрүүл мэндийн газраас Сүхбаатар сумын зорилтод бүлгийн сурагчдад эрүүл мэндийн боловсрол олгох, амьдралын буруу хэвшлээс татгалзаж, эрүүл, зөв дадлыг хэвшүүлэх зорилгоор “Миний гэр бүлийн эрүүл мэнд” сэдэвт сургалтыг 2014 оны 10 дугаар сарын 01-14-ний өдрүүдэд амжилттай зохион байгууллаа.

“Миний гэр бүл” хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд 50 хүүхэд тэдний гэр бүлд аймгийн Эрүүл мэндийн газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэс, Хаан банк, Төрийн банк, Хас банк болон төрийн бус байгууллагуудтай хамтран “Миний гэр бүлийн эдийн засаг”, “Миний гэр бүлийн хэрэгцээ”, “Мөнгөний үнэ цэнэ”, “Хүүхдийн мөнгө”, “Мөнгөө хэмнэе”, “Миний гэр бүлийн мөнгөний хайрцаг”, “Миний гэр бүлийн эрүүл мэнд” сэдвүүдээр тус тус сургалт зохион байгууллаа.

2. Нийгмийн халамжийн үйлчилгээний талаар:

Нийгмийн халамжийн тэтгэвэрт 3347 иргэнд 2838235.1 мянган төгрөг, нийгмийн халамжийн нөхцөлт мөнгөн тэтгэмжинд 1522 иргэнд 666222.5 мянган төгрөг, ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт тусламжинд 2380 иргэнд 248858.1 мянган төгрөг, амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламжинд 1205 иргэнд 352375.8 мянган төгрөгийг тус тус олголоо.

Хөгжлийн бэрхшээлтэй 625 иргэнд 107946.1 мянган төгрөгийн хөнгөлөлт үйлчилгээг, эхийн алдар одонтой 8560 эхэд 1168940.0 мянган төгрөгийн тусламжийг олголоо.

Жирэмсэн, хөхүүл нярай хүүхэдтэй 4657 эхэд 957629.9 мянган төгрөг, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 367 иргэнд 72692.9 мянган төгрөг, алдар цолтой ахмадуудад үзүүлэх хөнгөлөлт тусламжийн үйлчилгээнд 74 иргэнд 67845.0 мянган төгрөгийг тус тус олголоо.

3. Боловсролын талаар:

Дэлхийн багш нарын өдөр, Монголын багш нарын 48 дахь өдрийг 2014 оны 10 дугаар сарын 03-нд аймгийн хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлж, Монгол Улсын Засгийн Газрын болон Боловсрол, шинжлэх ухааны яам, Боловсролын газрын шагналаар шагнагдсан багш нарын шагналыг гардуулан, Улсын тэргүүний цэцэрлэгээр шалгарсан Хөтөл хотын 24 дүгээр цэцэрлэг, Улсын тэргүүний сургуулиар шалгарсан Мандал сумын 1 дүгээр сургуулийн багш, сурагчдын тоглолтыг зохион байгууллаа.

Багшийн мэргэжил дээшлүүлэх институтаас зохион байгуулж байгаа үндэсний сургалтанд 2013-2014 оны хичээлийн жилд 10, 11 дэх жилдээ ажилласан 7 багшийг оролцуулж, мэдлэг, чадварыг нь дээшлүүллээ.

2014-2015 оны хичээлийн жилийн эхлэл байдалтай танилцуулах зөвлөн туслах багийг аймгийн Боловсролын газраас 2014 оны 10 дугаар сарын 15-17-ны өдрүүдэд Орхон бүсийн ерөнхий боловсролын 5 сургууль, 5 цэцэрлэгт ажилууллаа.

Боловсролын үйлчилгээний сэтгэл ханамж, чанарын шинэчлэлийг хэрэгжүүлэх ажлын явц, үр дүн, тулгамдаж байгаа асуудлыг илрүүлэх зорилгоор аймгийн Боловсролын газраас 150 гаруй багш, 150 гаруй сурагч, 100 гаруй эцэг эхчүүдээс санал асуулга авлаа.

Аймгийн Боловсролын газар, Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуультай хамтран Бэлчир бүсийн ерөнхий боловсролын 8 сургуулийн бага ангийн 62 багштай уулзалт зохион байгуулж, бага боловсролын шинэчилсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тулгамдсан асуудал, хичээлийн төлөвлөлтийг хийхэд анхаарах асуудлын талаар хэлэлцүүлэг хийлээ.

"Ирээдүйн нисгэгч инженерүүд" аймгийн аварга шалгаруулах тэмцээн 2014 оны 10 дугаар сарын 17-19-ны өдрүүдэд Сүхбаатар суманд зохион байгуулагдлаа. Тус тэмцээнд нийт 25 сургуулийн 50 сурагч 26 багш оролцож, Шүхрийн буултын талбайдээр 36 онгоц, нисгэгч өрсөлдлөө.

4. Хөдөлмөр эрхлэлтийн талаар:

2014 оны 9-р сарын байдлаар бүртгэлтэй ажилгүй иргэд 835 хүн байсан бол 684 иргэн шинээр бүртгүүлж, ажил олгогчоос ирүүлсэн 252 ажлын байранд 302 хүнийг ажилд зуучлан, идэвхгүйн улмаас 365 иргэн хасагдаж, бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 852 боллоо.

Аймгийн Хөдөлмөрийн хэлтсээс Түшиг, Ерөө сумдын Засаг даргын тамгын газар, ажил олгогчидтой хамтран ажлын байрны өдөрлөг уулзалтыг зохион байгуулж, хөдөлмөр эрхлэлтийн төсөл хөтөлбөр, арга хэмжээнд хамрагдсан иргэдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээр үзэсгэлэн гаргалаа.

Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангийн төсөл сонгон шалгаруулах 2 дугаар ээлжийн хурлыг 10 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулж, нийт 1240.0 сая төгрөгийн санхүүжилт хүссэн 15 төсөл ирснээс 7 аж ахуйн нэгж, 2 иргэний төслийг дэмжин 600.0 сая төгрөгийн санхүүжилтэнд хамруулахаар Хаан, Хас, Төрийн банкинд хүргүүлээ.

Түшиг, Ерөө, Цагааннуур сумдын ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчид, Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 6-р сургуулийн 9-12 ангийн сурагчид болон Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн оюутнууд зэрэг нийт 430 гаруй сурагчдад "Мэргэжил бүхэн сайхан" сургалтыг зохион байгууллаа.

Сумдын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн гурван талт салбар хорооны гишүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор 2014 оны 10 дугаар сарын 14, 15-ны өдрүүдэд сумдын Засаг даргын Тамгын газрын Хөдөлмөр эрхлэлт хариуцсан мэргэжилтэнүүдэд сургалт зохион байгууллаа. Мөн "Бороо-гоулд" ХХК-ийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагаатай танилцаж "Осолгүй үйлдвэрлэл" сэдэвт үзүүлэх сургалтыг амжилттай зохион байгууллаа.

5. Нийгмийн даатгалын үйлчилгээний талаар:

2014 оны 10 дугаар сарын 25-ны байдлаар аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь Нийгмийн даатгалын сангуудад 19.6 тэрбум төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл оруулах төлөвлөгөөтэйгээс 19.5 тэр бум төгрөг хурааж, төлөвлөгөөний биелэлт 99.4 хувьтай байна. Аймгийн хэмжээнд 19 нэгжээс 11 сум нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг 1-65 хувиар давуулан биелүүлж, 8 сум 4-18 хувиар төлөвлөгөөг тасаллаа.

Тайлант хугацаанд тэтгэврийн даатгалын сангаас 13720 тэтгэвэр авагчдад 28.7 тэр бум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын сангаас 4704 даатгуулагчдын хөдөлмөрийн чадвар түр алдалт, жирэмсэн амаржсан, оршуулгын зардалд 1426.2 сая төгрөг олголоо.

Эрүүл мэндийн даатгалын сангаас нийт 9 эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн 30 эмийн сангаар үйлчлүүлсэн 51734 даатгуулагчийн эмийн үнийн хөнгөлөлт, эмчилгээний зардалд 2348.4 сая төгрөг шилжүүлээд байна.

Ажилгүйдлийн даатгалын сангаас 325 даатгуулагчид 339.0 сая төгрөгийн тэтгэмж олголоо.

Шинээр энэ сард 11 аж ахуйн нэгж, 29 даатгуулагчийг нийгмийн даатгалд хамрууллаа.

Тав.Үйлдвэр, хөдөө аж, ахуйн бодлогын хүрээнд:

2014 онд үр тариа 241.8 мянган тн, тэжээлийн ургамал 6.7 мянган тн, тосны ургамал 20.7 мянган тн, төмс 46.0 мянган тн, хүнсний ногоо 31.4 мянган тн хураан авч, сүүлийн 26 жил аваагүй ургац буюу 1988 онд хураасан амжилтаа дахин бататгалаа.

“Хамгаалагдсан тариалан” хөтөлбөрийн 2-р шатны хэрэгжилтийг хангаж 15300 метр торон хашаа барих тендерт шалгарсан “Товбаржурла” ХХК-иас хүлээн авч, сумдад хувиарлах ажлыг зохион байгууллаа.

ОХУ-аас улаанбуудайн 8 сортын 9.7 тн элит үрээр тариалалт хийснээс 7 сумын 19 аж ахуйн нэгжийн 4200 га талбайд сортын улаанбуудайн хянан баталгаа хийж, улсын үрийн нөөцөд 620 тн, тариалан эрхлэлтийг дэмжих санд 700 тн-ыг нөөцлөөд байна.

Өнөөдрийн байдлаар 992 га-д жимс, жимсгэнэ тариалж, 83.5 тн ургац хураан авч байна.

Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам, аймгийн Үйлдвэр хөдөө аж ахуйн газар хамтран иргэдийн жимс жимсгэнэ худалдах орчныг бий болгож, Улаанбаатар хотод нийт сумдын 40 жимс, жимсгэнэ тариалагч иргэд 30 тн жимс жимсгэнийг борлуулаад байна.

2014 онд бэлчээрийн хөнөөлт мэрэгч амьтантай тэмцэх ажлыг Мандал, Баянгол, Сайхан, Орхон, Орхонтуул, Сант, Баруунбүрэн сумдад 83.2 хувийн гүйцэтгэлтэйгээр хийлээ.

Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамнаас Зөгийн аж ахуй эрхлэгчдийг дэмжих төслийн шалгаруулалтанд тус аймгийн Шаамар, Сүхбаатар, Зүүнбүрэн, Цагааннуур, Түшиг сумдын 18 иргэн аж ахуй нэгж шалгарч, Оросын холбооны улсын Башкирын автономит улсаас оруулж ирсэн 800 бүл зөгийнөөс 190 бүл зөгийг хүлээн авлаа.

Швейцарийн хөгжлийн агентлагийн Малын эрүүл мэнд төслийн дэмжлэгтэйгээр аймгийн хүн, мал эмнэлгийн эмч, мэргэжилтнүүд хамтран бруцеллёзын вакцинжуулалтын дараах ийлдэс судлалын тандалт судалгааг 2 сумын 40 өрхийн нийт 1080 толгой малаас дээж авсан дүнтэй байна.

Зургаа. Газрын харилцаа, барилга хот байгуулалтын чиглэлээр:

1. Газрын харилцааны талаар:

Тайлант сард аймгийн Засаг даргын 6 удаагийн захирамжаар өмнө нь гэр бүлийн хамтын хэрэгцээнд дундаа газар өмчилж авсан иргэдийн хамтран өмчлөгч хасуулах хэлцлийг үндэслэн нийт 6 иргэний газар өмчлөх эрхийг хэвээр үлдээж, 19 иргэний газар өмчлөх эрхийг нээлээ.

Цагааннуур суманд үр тарианы 12 аж ахуйн нэгжийн 147 нэгж, Хүдэр сумын үр тарианы Ургац Хүдэр ХХК-ийн 150 нэгж талбарын хувийн хэргийн анхан шатны өргөдөл материалын бүрдүүлэлтийг хийж, сумын Засаг даргын захирамж гарган нэгж талбарын хувийн хэрэг үүсгэлээ.

Газар эзэмших, ашиглах эрхээ арилжааны болон банк бус санхүүгийн байгууллагад зээлийн барьцаанд тавих хүсэлт гаргасан нийт 50 иргэний нийт 50 нэгж талбарын газар эзэмших эрхийн гэрчилгээг барьцаалсан тухай улсын бүртгэлд бүртгэж аймгийн төрийн сангийн 130000941 тоот дансанд 500.0 мянган төгрөгийг төвлөрүүлээ.

2. Барилга хот байгуулалтын чиглэлээр:

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа Сүхбаатар сумын 4-р багийн дулаан, цэвэр усны магистрал шугамын өргөтгөлийн ажлыг “Набсан” ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд айл өрх, албан байгууллагууд 2014 оны 10-р сарын 23-ны өдөр дулаанаар хангаж холбогдлоо.

Цагааннуур суманд хийгдэж буй “Сумын төвийн шинэчлэлтийн” ажлын шугам сүлжээний ажил 90 хувь, зуухны барилга 90 хувьтай байна. Халаалтын тогоо угсарч эхэлсэн, төсвийн байгууллагуудыг хуучин халаах зуухаар галлаж халааж байгаа бөгөөд санхүүжилт удаашралтай байгаа тул ажил удааширч эхлээд байна.

Ерөө сумын төвийн гэрэлтүүлгийн ажил, Жавхлант сумын хайрган хучилттай авто замын ажил, Алтанбулаг сумын нийтийн орон сууцны барилгын

сантехникийн засварын ажил, Жавхлант, Ерөө, Бугант, Хүдэр сумдын интернет холболтын ажил, Сант сумын явган хүний зам дагуу хийгдсэн гэрэлтүүлгийн ажил, Өвсний үндэс төслөөр хийсэн Сайхан сумын 12 жилийн сургуулийн дээвэр засварын ажилд улсын комисс ажиллуулан байнгын ашиглалтанд хүлээлцүүлээ.

Мандал сумын Спорт сургалтын төвийн ажил, Алтанбулаг сумын нутагт хийгдсэн аялал жуулчлалын цогцолборыг цахилгаанаар хангах ажлыг улсын комиссоор хүлээн авч байнгын ашиглалтанд хүлээлцүүлээ.

Долоо. Байгаль орчны чиглэлээр:

Байгаль орчин ногоон хөгжлийн сайдын А/204 тоот тушаалаар аюултай хог хаягдал, устгах шаардлагатай химийн хорт болон аюултай бодисын тооллогыг хийлээ. Тооллогоор Сэлэнгэ аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын 35 сургуулиас 14 сургууль химийн бодис ашиглаж байна. Эдгээр сургуулиудад устгах шаардлагатай 304 төрлийн бодис, нэр төрөл тодорхойгүй 61 бодис, нийт 365 бодис сургуулийн химийн лабораторид хадгалагдаж байна. Устгах шаардлагатай химийн бодисын нийт хэмжээ ерөнхий боловсролын сургуульд 947.6 кг орчим байна. Мөн аж ахуй нэгж, байгууллагуудад хадгалагдаж байгаа устгах шаардлагатай бодисын нийт хэмжээ 25295.4 кг бодис тоологдлоо.

Сүхбаатар суманд агаарын бохирдол, гадаргын усны гидрохимийн шинжилгээ, цацрагийн түвшин нь стандарт хэмжээнээс хэтрээгүй байна.

Агаар дахь түгээмэл бохирдуулагч хий болох азотын давхар ислийн дундаж агууламж 0.016 мг/м^3 , хамгийн их агууламж $0,027 \text{ мг/м}^3$, хүхэрлэг хийн дундаж агууламж $0,004 \text{ мг/м}^3$, хамгийн их агууламж $0,007 \text{ мг/м}^3$, агаар дахь тоосжилтын дундаж агууламж $0,021 \text{ мг/м}^3$, хамгийн их агууламж $0,028 \text{ мг/м}^3$, нүүрс хүчлийн дутуу исэлийн дундаж агууламж $0,023 \text{ мг/м}^3$, хамгийн их нь $0,064 \text{ мг/м}^3$ байлаа.

Найм.Тээвэр авто замын талаар:

Аймгийн Тээвэр авто замын газраас намрын ургац хураалт, нүүрс тээвэрлэлт, улс хооронд, орон нутаг, хот хоорондын ачаа зорчигч тээвэрлэлтийн үйл ажиллагаа явуулдаг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын авто тээврийн хэрэгслүүдийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон даац, зорчигч тээвэрлэлтийн норм, техникийн бүрэн бүтэн байдал зэрэгт “Автотээврийн тухай хууль” болон холбогдох хууль, дүрэм, журам, стандартын шаардлагыг хэрхэн хэрэгжүүлж байгаа, автотээврийн хэрэгслийн техникийн улсын үзлэг оношлогоонд хамрагдсан эсэхэд авто тээврийн хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

“Ургац тээвэрлэлтийн сарын аян”-ы хүрээнд орон нутагт Дулаанхаан 4-н замын пост, Шарын голын гүүр, Сүхбаатар самбар, Шаамарын гүүр зэрэг газруудад автотээврийн хяналт шалгалтыг шуурхай, үр дүнтэй зохион байгуулан ажиллаж байна. Сүхбаатар самбар, Шаамарын гүүр, Дулаанхан 4-н замын постоор нэвтрэн өнгөрч байгаа тээврийн хэрэгслүүд болон хүнд даацын машин, механизмуудад хяналт шалгалт хийж, нийт 62 тээврийн хэрэгслийг хамруулж, 42 зөрчлийг илрүүлэн, газар дээр нь арилгуулж, 31 зөрчилд “Автотээврийн тухай хууль”-ийн дагуу захиргааны арга хэмжээ авч 130.0 мян/төг-ийн торгууль шийтгэврийг оногдуулан барагдууллаа.

Баянгол сумын 1.6 км хайрган хучилттай зам засварын ажил, Хүүдэр сумын Хүдэр гол дээрхи 72.8 у/м төмөр бетонон гүүрийг Улсын комист хүлээн авч, орон нутагт хүлээлгэн өглөө.

Найм.Сум орон нутгийн талаар:

1.Алтанбулаг сум:

Сумын Засаг даргын Тамгын газраас сумын хэсгийн төлөөлөгч, Алтанбулаг худалдааны чөлөөт бүсийн цагдаа нарын хамтын ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор “Гэмт хэргээс хэрхэн урьдчилан сэргийлэх вэ?” сэдэвт сургалтыг зохион байгууллаа.

Аймгийн Онцгой байдлын газар, тус сумын Засаг даргын Тамгын газар, эрүүл мэндийн төв, ерөнхий боловсролын сургууль хамтран гамшгаас урьдчилан сэргийлэх “Говийн баавгай мазаалай” сэдэвт сургалтыг зохион байгуулж, нийт 223 сурагчийг хамрууллаа.

“Дэлхийн зөн” олон улсын байгууллагаас 2014 оны 10 дугаар сарын 16-ны өдөр тус сумын төр, төсвийн 6 байгууллагын дунд танин мэдэхүйн “АСТ” тэмцээнийг зохион байгуулж, сумын Засаг даргын Тамгын газар тэргүүлж, ерөнхий боловсролын сургууль 2-р байранд шалгарлаа.

2.Баянгол сум:

Сумын Засаг даргын 2014 оны А/206 тоот захирамжаар Баянгол сумын нутаг дэвсгэрт байгаа булш, хиргисүүр, хөшөө, чулуу хадны бичээс зэрэг түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийг орон нутгийн хамгаалалтанд авлаа.

Тус суманд БНСУ-ын баатар Ха Сою хүрэлцэн ирж иргэд хөдөлмөрчидтэй уулзалт зохион байгуулан, БНСУ-ын баатар хэмээх цолыг хэрхэн хүртсэн талаарх баримтат киног үзүүллээ.

Сумын Засаг даргын 2014 оны А/195 тоот захирамжаар томилогдсон ажлын хэсэг тус суманд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн Соёлын төв, спорт цогцолборын засварын ажлыг хүлээн авлаа.

“Гэр бүлийн хөгжлийг дэмжих жил”-ийн хүрээнд Монгол гэр бүлийн уламжлал, ёс заншлыг сахин хамтдаа 50 гаруй жил амьдарч, 8 хүүхэд төрүүлж өсгөсөн, авто замын байгууллагад олон жил үр бүтээлтэй ажилласан тус сумын ахмад настан С.Очирбат, А.Хажидсүрэн нарын гэр бүлд сумын Засаг даргын талархал дэвшүүлж, дурсгалын зүйл гардууллаа.

3.Жавхлант сум:

Сумын 2014 оны ургац хураалтын эцсийн мэдээгээр үр тариа 5819 тн, тосны ургамал 1267 тн, тэжээлийн ургамал 1160 тн, төмс 279 тн, хүнсний ногоо 1121 тн ургац тус тус хураан аваад байна.

Тус сумын Засаг даргын Тамгын газар, Залуучуудын холбоотой хамтран “Нар дагуулсан намрын өдрүүд” сайн үйлсийн аяныг зохион байгуулж, “Бадрал Трейд” ХХК-ийн намрын ажилд нэг өдөр ажиллалаа.

Аймгийн хөрөнгө оруулалтаар тус сумын Моностой 2-р багийн Хавтгай нарсанд 15 га газарт Алтанбулаг сумын “Өргөн Сэлэнгэ” ойн нөхөрлөл нь ойжуулалтын ажлыг хийж гүйцэтгэлээ. Мөн Жавхлант сумын Байгаль хамгаалах сангаас 750.0 мянган төгрөгийн зардлыг нь гаргаж 1.5 га газарт 3000 ширхэг нарсны суулгацыг Хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй 10 иргэнээр тарьж суулгууллаа.

4.Зүүнбүрэн сум:

Тус суманд 2014 оны 10 дугаар сарын 15-ны өдөр сум дундын 20 дугаар шүүхээс “Нээлттэй шүүх өдөрлөг” арга хэмжээг зохион байгуулж, иргэдэд хууль, эрх зүйн талаар мэдээ мэдээлэл өгч, байгууллага ард иргэдийн дунд гар бөмбөгийн тэмцээн зохион байгууллаа.

Сумын Засаг даргын Тамгын газар, ерөнхий боловсролын бүрэн дунд сургууль, Дэлхийн зөн олон улсын байгууллагаас хамтран “Алтан намар”, “Намрын спартакад” арга хэмжээг зохион байгууллаа. Тус арга хэмжээний үеэр иргэдийн хүнсний ногоогоор хийсэн бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдааг зохион байгууллаа.

“Эх хүүхдийн эрүүл мэндийг дэмжих жил”-ийн хүрээнд 2014 оны 10 дугаар сарын 16-ны өдөр тус сумын Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн төв, Соёл мэдээллийн төв, Дэлхийн зөн олон улсын байгууллага, хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль хамтран “Эх хүүхдийн эрүүл мэндийг дэмжихэд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нь” сэдвээр зөвлөгөөн зохион байгууллаа.

5.Ерөө сум:

2014 оны 10 дугаар сарын 22-ны өдөр тус сумын Засаг даргын Тамгын газраас томилогдсон ажлын хэсэг Хандгайт, Энхталын чиглэлийн малчин өрхүүдийн өвөлжилтийн бэлтгэл байдалтай танилцлаа. Малчдынхаа амьдрал ахуй болон өвс тэжээл, түлээ модоо бэлтгэсэн байдалтай нь танилцан сумын өвсний фондны өвсийг өрх бүр 10 бухлаар тооцон нөөцлөсөн байдалтай байлаа. Мөн 10-р сарын 24-нд Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн, Орхон суманд фермерийн чиглэлээр туршлага судлуулахаар 6 малчинд уг ажлын талаар танилцуулж, хамруулахаар боллоо.

Тус сумын Хандгайтын чиглэлийн малчдын малд “Дуут хавдар”-ын шинж тэмдэг илэрч бага насны мал үхэж, өвчилсөн байсныг сумын Засаг даргын Тамгын газар болон хувийн мал эмнэлэгтэй хамтран газар дээр нь очиж малчидтай уулзан өвчилсөн малыг эмчилж, өвөлжөө, намаржааг ариутган, үхсэн малын сэг зэмийг устган, өвчин гарсан айл өрхийг тусгаарлалт хийж, 5 хоног малын хөдөлгөөнийг хязгаарлалаа.

Ерөө сумын Засаг даргын 17 тоот захирамжийн дагуу жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “Өвөл цагийн соёл, хүмүүжлийн ажил”-ийн нээлтийн арга хэмжээг 2014 оны 10 дугаар сарын 16-19-ний өдрүүдэд зохион байгууллаа.

Тус сумын Засаг даргын Тамгын газар, Ерөө бүсийн сум дундын ойн анги хамтран хууль бус мод бэлтгэлийг таслан зогсоох зорилгоор 7 удаагийн эргүүл шалгалтаар илэрсэн 206.6 м³ модонд экологи эдийн засгийн үнэлгээг тогтоож, 10598.5 мянган төгрөгийн торгууль, 31795.7 мянган төгрөгийг нөхөн төлүүлэхээр ажиллаж байна.

6.Түшиг сум:

Сумын Засаг даргын 2014 оны А/110 тоот Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх тухай захиражийн хэрэгжилтийг хангаж, 2014 оны 09 сарын 20-оос 11 сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд ойд мод бэлтгэх, ойн дагалт баялаг ашиглах, ан хийх болон бусад үйл ажиллагааг явуулахыг хориглон эргүүл шалгалтын ажлыг тогтмол хийж байна.

Тус суманд “Шинэ бадрах” ХХК 200 га талбайд нарс, “Мойлт нуга ХХК” 70 га газар өөрийн хөрөнгөөр ойжуулалтын ажлыг тус тус хийлээ.

Сумын Засаг даргын Тамгын газар, Хачигт халдварын төслийн багтай хамтран сумын малчин болон мал бүхий иргэдийн Үхэр 50, адуу 50, хонь 58, ямаа 58 нийт 216 малаас дээж авч шинжилгээнд явууллаа.

7.Мандал сум:

Сумын ерөнхий боловсролын сургууль, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв хамтран охидын эрүүл мэнд, гоо зүй болон сэтгэл зүйн боловсролыг дээшлүүлэх, олон нийтийн дунд биеэ зөв боловсон авч явах ахуйн соёлыг төлөвшүүлэх зорилгоор “Төгс ертөнц” өдөрлөгийг зохион байгуулж, нийт 420 гаруй охид оролцлоо.

Мандал сумын Засаг даргын Тамгын газраас тус сумын хүнсний талон авдаг 30 өрхөд “Аюулгүй гэр бүл” сургалтыг зохион байгууллаа.

Сумын Засаг даргын Тамгын газар, орон нутгийн Мандал телевизтэй хамтран “Гэр бүлийн хөгжлийг дэмжих жил”-ийн ажлын хүрээнд “Аз жаргалтай гэр бүл” телевизийн шууд нэвтрүүлгийг долоо хоног бүрийн бямба гарагт үзэгчдэд хүргэж эхлээд байна.

Сумын Засаг даргын Тамгын газар, “Аюулгүй хөдөлмөрийн үндэс” төрийн бус байгууллагатай хамтран “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй” сургалт зохион байгуулж, Мандал суманд ойн сан гэрээгээр эзэмшдэг 11 нөхөрлөлийн гишүүдийг хамрууллаа.

8.Шаамар сум:

Тайлант сард тус суманд шинээр төрсөн 6, шилжин явсан 6, бусад аймаг сумаас 3 иргэн шилжин ирлээ.

Аймгийн Засаг даргаас санаачлан Орхон аймагт зохион байгуулсан “Сэлэнгэд үйлдвэрлэв” үзэсгэлэн худалдаанд тус сумын 21 зөгийчин, ногоочин 5 иргэн оролцож 600 кг зөгийн бал, 1.3 тн хүнсний ногоо 800 шил савласан хүнсний ногоог худалдан борлууллаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг бүх нийтээр мод тарих үндэсний өдрөөр тус сумын иргэд 800 м газарт 300 ширхэг нарс модыг шилжүүлэн суулгах аргаар тариаллаа.

9.Сайхан сум:

Сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын газраас ахмадын баярыг тохиолдуулан ахмадууддаа хүндэтгэл үзүүлэн “Ахмадаа хүндэлье” хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулан, байнгын асаргаанд байдаг 20 ахмад настанд сумын Засаг даргын Тамгын газраас тус бүр 20.0 мянган төгрөгийн хүндэтгэл үзүүллээ.

Тус сумын Засаг даргын Тамгын газраас Гавшгай 2-р багийн төвийн болон гэр хорооллын үерийн жалга гууг цэвэрлэх ажлыг зохион байгуулж, 75 тн хог хягдлыг цэвэрлэж, 15 иргэнийг түр ажлын байраар хангаж ажиллалаа.

“Дэлхийн зөн Монгол” олон улсын байгууллагаас тайлант сард тус суманд “Гэр бүлийн баяр хөөр” сэдэвт сургалтыг сумын нийт аж ахуй нэгж, төр төсвийн байгууллагатай хамтран зохион байгууллаа.

Монголын залуучуудын холбооны байгууллага үүсэн байгуулагдсаны 93 жилийн ойг угтаж сумын хэмжээнд хөл бөмбөгийн тэмцээнийг зохион байгуулж, нийт 12 багийн 120 гаруй тамирчид оролцлоо.

10.Сүхбаатар сум:

2014 оны 10-р сарын 07-10-ны өдрүүдэд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороо, аймгийн Хөдөлмөрийн хэлтсээс тус сумын Засаг даргын Тамгын газарт Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хуулийн хэрэгжилтэнд хяналт, шалгалтыг хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, цаашид хуулийн хэрэгжилтэнд анхааран ажиллах зөвлөмжийг өглөө.

Тус сумын Засаг даргын Тамгын газар, ерөнхий боловсролын сургуулиудтай хамтран “Хариу нэхээгүй тус” аяныг өрнүүлж, аяны хүрээнд ахлах ангийн сурагчид өөрийн багт оршин суудаг ахмадууддаа хашааны зэрлэг түүх, мод хагалах, ус дөхүүлж өгөх, хашаа хороог засаж сэлбэж өгөн, дунд ангийнхан урлагын тоглолт үзүүлэн сэтгэлийн дэм хайрлан хүндэтгэл үзүүллээ.

Сүхбаатар сумын Засаг даргын Тамгын газар, сумын Тохижилт үйлчилгээний газартай хамтран золбин нохой устгалын ажлыг 2014 оны 10 дугаар сарын 09-15-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Сүхбаатар сумын Засаг даргын Тамгын газраас тус суманд Согтууруулах ундаагаар үйлчилдэг дэлгүүрүүдэд “Ариун цэврийн тухай”, “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай”, Захиргааны хариуцлагын тухай”, “Тамхины хяналтын тухай”, Архидан согтуурахтай тэмцэх тухай” “Аж ахуйн нэгжийн үйл ажилгааны тусгай зөвшөөрлын тухай хууль”, Худалдаа худалдааны газар түүний үйлчилгээ MNS 5021-2005 стандартын хэрэгжилтийг шалгах, гарсан зөрчлийг арилгуулах, хууль эрх зүйг хэрэгжүүлэх арга зүйн зөвлөгөө өгөх зорилгоор 2014 оны 10 сарын 6-аас 3 өдөр хяналт шалгалтын ажлыг зохион байгууллаа.

11.Хушаат сум:

Тус сумын Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг сумын Эрүүл мэндийн төв, ерөнхий боловсролын сургуульд хууль эрх зүйн хэрэгжилт, нийгмийн даатгалын шимтгэл, цалин хөлс тогтоолт, архив албан хэрэг хөтлөлт, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдалд хяналт шалгалтын ажлыг зохион байгууллаа.

Ногооны талбайд мал оруулсан гэх иргэдийн гомдлын дагуу тус сумын Засаг даргын Тамгын газраас 3 удаа газар дээр нь групп томилон ажиллуулж, “Малчид

тариаланчдын үйл ажиллагааны зохицлыг хангах журам"-ын дагуу хохирлыг тогтоон, ногоочдын хохирлыг барагдууллаа.

Мэдээллийн Технологи Шуудан харилцаа холбооны газар, Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн захиалгаар ШУТИС-ийн профессор, багш нарын бэлтгэсэн "Хөдөө орон нутгийн иргэдэд мэдээлэл, харилцаа холбооны мэдлэг олгох" сургалтыг тус суманд 2014 оны 10 сарын 04-ний өдөр зохион байгуулж, сумын төр, төсвийн байгууллагын ажиллагсад, иргэд оролцож компьютер, интернетийн хэрэглээ, тоон өргөн нэвтрүүлэг, гар утасны хэрэглээ, хиймэл дагуулын хүлээн авах антенныг тохируулахад шаардагдах өгөгдөл зэрэг өргөн хүрээний мэдлэгийг хүлээн авлаа. Багш нар байгууллага бүрт мэдээлэл харилцаа холбооны технологийн хэрэглээний сурах бичиг, оролцогч бүрт гарын авлага тараалаа.

12.Хүдэр сум:

Сумын Засаг даргын Тамгын газар, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлтэй хамтран ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад "Насанд хүрээгүй хүмүүсээс үйлдэгдэж буй гэмт хэрэг түүний шалтгаан нөхцөл цаашид авах арга хэмжээ" сэдэвт сургалт зохион байгууллаа.

Аймгийн Байгаль орчны газраас орон нутгийн төсвийн хөрөнгөөр нарс модны насны 1, 2-р ангид арчилгааны огтлолт 25 га талбайд хийж гүйцэтгэлээ.

Тус сумын Ойн анги нь 60.0 мянган шихэг нарсыг 24 га талбайд, 3000 ширхэг чацарганы тарьцаар тус тус ойжуулалтын ажлыг хийлээ.

Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд тайлант сард бруцеллээс өвчнөөс сэргийлэх тарилганд 6500 тугал, хурга, ишиг хамрагдаад байна. Өссөн дүнгээр нийтдээ 23.0 мянган мал халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэхээр тарилганд хамрагдлаа.

13.Орхонтуул сум:

Тайлант сард тус сумын Засаг даргын 2014 оны А/43 тоот захирамжаар сумын Засаг даргын нэрэмжит үзлэгийг төр, төсвийн байгууллагуудыг хамруулан зохион байгууллаа.

Тус сумын Засаг даргын Тамгын газраас Рашаант тосгоны иргэдэд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны 25 тоот тогтоолоор батлагдсан "Малчид, тариаланчдын үйл ажиллагааны зохицлыг хангах журам"-ын талаар мэдээлэл хийж, Газрын тухай хуулиар сургалт зохион байгууллаа.

Сайхан сумын "Адонис" эмнэлгийн "Монгол цагаан барбад" сувиллын эмч, сувилагч нар тус сумын өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд 10 хоногийн эрүүл мэндийн үйлчилгээг үзүүллээ.

Тус сумын Засаг даргын шийдвэрээр бүх нийтийн цэвэрлэгээ явуулах 14 хоногийн аяныг зарлаж, төр төсвийн болон аж ахуйн нэгж байгууллага 2014 оны 10-р сарын 24-ний өдөр нийтийн эзэмшлийн зам талбайн хог цэвэрлэгээний ажлыг эхлүүллээ.

14.Орхон сум:

Тайлант хугацаанд аймгийн Онцгой байдлын газраас Орхон суманд "Намар нэгдсэн арга хэмжээ" зохион байгууллаа. Тус арга хэмжээний хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд "Говийн байвгай" сэдэвт газар хөдлөлтийн бэлэн байдлын талаар үзүүлэх сургалтыг зохион байгуулж, нийт 91 багш, сурагчдыг оролцууллаа. Мөн тус сумын төр төсвийн байгууллагуудын гамшгийн бэлэн байдлын төлөвлөгөөтэй танилцаж, зөвлөн туслах ажлыг зохион байгууллаа.

Орхон сумын хэмжээнд 1321 толгой гүү, 4495 толгой үнээ нийт 5810 толгой бод мал хээлтүүлэгт хамрагдахаас 935 толгой гүү, 3825 толгой үнээ, бүгд 4760 толгой бод мал хээлтүүлэгт хамрагдаж хээлтүүлгийн ажлын гүйцэтгэл 81.8 хувьтай байна.

2014 онд сумын хэмжээнд 101.0 мянган толгой мал буюу хонин толгойд шилжүүлснээр 187355 мал өвөлжихөөр урьдчилан тооцоо хийгдээд байна. Сумын хэмжээнд нийт малчин, мал бүхий өрх 5447 тн байгалийн хадлан, 300 тн сүрэл, 1367 тн ногоон тэжээл, 2072 тн хүчит тэжээл бэлтгэлээ. Мал сүргийн өвөлжилт хаваржилтын бэлтгэл хангасан ерөнхий үзүүлэлт сумын дүнгээр 96.3 хувьтай байна.

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор гахай, тахианы аж ахуй эрхлэгч иргэн, мал бүхий өрхийн 6 тахианы байрны 72 м², 22 гахайны байрны 264 м² талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийлээ.

15.Цагааннуур сум:

Тус сумын төр төсвийн байгууллага, аж ахуйн нэгжүүдийн удирдлагуудын цугларалтыг 10 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулж, сумын Засаг дарга цаг үеийн ажлын талаар, Засаг даргын орлогч сумын нийгэм эдийн засгийн эхний 3 улирлын үзүүлэлт, газрын даамал газар зохион байгуулалт, газар өмчлөх, эзэмших өргөдлийн шийдвэрлэлтийн талаар, төрийн санч төсвийн талаар тус тус мэдээлэл өгч ажиллалаа.

Хөдөлмөрийн яам, аймгийн Хөдөлмөрийн хэлтэс, тус сумын Засаг даргын Тамгын газар хамтран, Цагааннуур сумын нийт төгсөх ангийн сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг 2014 оны 10 сарын 03-ны өдөр зохион байгууллаа.

Цагааннуур суманд аймгийн Сум дундын 20-р шүүхийн “Нээлттэй шүүх өдөрлөг” 2014 оны 10 сарын 14-ны өдөр зохион байгуулагдаж, иргэдэд үнэ төлбөргүй эрх зүйн зөвлөгөө мэдээллээр үйлчиллээ.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР